



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/122

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1, Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөн гол эрдэнэ ХХК нь (4396839) Сүмбэр сумын 3 дугаар багт Грийн хаус хоолны газрын урд талд байрлах автомашины засвар, үйлчилгээний зориулалттай 1500м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Боржигин овогт Зоригтын Дашнямд (ЕЙ92070532) Сүмбэр сумын 3 дугаар багт Гомбосүрэн ноёны өргөн чөлөө 3-300д тоотод байрлах 1500м² газрыг автомашины засвар, үйлчилгээний зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (З.Дашням)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч иргэн З.Дашнямд эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/85 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400304



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 сарын 29-ны өдрийн А/122 дугаар
захирамжийн хавсралт



Боржигин овогт Зоригтын Дашнямын эзэмшилд
шилжүүлж байгаа газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	3	1500	9	Автомашин засвар, үйлчилгээ	Гомбосүрэн ноёны өргөн чөлөө 3-300д

